


# ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

07.27 - 07.31



## ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

**АНУ:** Энэ долоо хоногт 2-р улирлын санхүүгийн тайлангууд болон эдийн засгийн үзүүлэлтүүд нийтлэгдсэнтэй холбоотой АНУ-ын хөрөнгийн зах зээлийн ихэнх индексүүд өсөлттэй хаагдлаа. Урт хугацаат бондын өгөөжүүд буурснаар, S&P500 индексийн сагсанд багтах үл хөдлөх хөрөнгийн хөрөнгө оруулалтын сангууд хамгийн их өсөлттэй байлаа. Мөн Apple, AMD, Qualcomm зэрэг технологийн салбарын компаниудын хувьцааны өсөлт тус индексийн ханшид эергээр нөлөөлжээ. Харин эрчим хүчний салбар хамгийн их уналттай байсан бөгөөд, үндэс Chevron, ExxonMobil зэрэг компаниудын 2-р улирлын орлогын тайлангийн алдагдлууд нөлөөлсөн байна.

Refinitiv агентлагийн мэдээлснээр S&P 500 индексээс 189 компани 2-р улирлын тайлангаа ил болгосон байна. Төрөлжсөн аж үйлдвэрлэл болон түүхий эдийн салбарын 3М, Ecolab зэрэг компаниудын борлуулалтын орлого эрс буурсан нь цар тахлын зах зээлд үзүүлсэн нөлөө нь маш хүчтэй байсныг илтгэж байна. Шинжээчдийн таамаглаж байгаагаар S&P 500 индексийн сагсанд багтах компаниудын нийт орлого өмнөх оны мөн үеийнхээс 36%-аар буурна гэж үзэж байгаа нь 2008 оны хямралаас хойш байгаагүй муу үзүүлэлт болж байна.

**Европ:** Коронавирусийн халдварын дахин дэгдэлт, АНУ болон БНХАУ-ын хурцадмал байдал болон компаниудын орлогын тайлан муу гарж байгаа нь Европын хөрөнгийн зах зээлийн индексүүдийг энэ долоо хоногт уналттай байхад нөлөөллөө. STOXX Europe 600 индекс 3.0%-аар, DAX индекс 4.1%-аар, CAC 40 индекс 3.5%-аар, FTSE 100 индекс 3.7%-аар тус тус буурсан байна.

Цар тахлаас үүдэн ХБНГУ болон Франц улсад урьдчилсан дүнгээр өрхийн хэрэглээ, хөрөнгө оруулалт, болон экспорт буурч, эдийн засаг эрс уналтад орсон байна. ХБНГУ-ын ДНБ нэг улиралд 10.1%-аар буурсан бол хол хорио илүү хатуу байсан Франц улсын ДНБ 13.8%-аар буурсан байна.

**Япон:** Япон улсын хөрөнгийн зах зээлийн индексүүд 5 өдөр дараалан унаж, 4-р сараас хойших хамгийн муу үзүүлэлтээ харууллаа. Nikkei 225 Stock Average индекс 1,042 пункт буюу 4.6%-аар буурч 21,710.00 болсон нь өнгөрсөн жилийн мөн үеийнхээс 8.2% бага байгаа юм. TOPIX индексүүдийн хувьд large-сар буюу томоохон компаниудын хувьцааны индекс болон small-сар буюу жижиг компаниудын хувьцааны индекс аль аль нь буурсан байна. Харин иений ханш харьцангуй чанга арилжаалагдаж, Баасан гарагт 1 ам.доллар 105 иентэй тэнцэж байв.

**БНХАУ:** АНУ болон БНХАУ-ын харилцаа хурцадмал байдалд ороод байгаа ч эдийн засгийн үзүүлэлтүүд сайн гарсантай холбоотойгоор БНХАУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд өсөлттэй хаагдсан байна. CSI 300 large-сар индекс 4.2%-аар, Shanghai composite индекс 3.5%-аар тус тус өсжээ. А ангиллын хувьцаануудын хувьд жижиглэнгийн хөрөнгө оруулагчдын орох мөнгөн урсгалыг мэргэжлийн хөрөнгө оруулагчдын гарах мөнгөн урсгал давж гарснаар Баасан гарагт буурсан байна. Northbound Stock Connect-ийн (Хонг Конгод байрших гаднын хөрөнгө оруулагчид БНХАУ-ын хувьцаануудад хөрөнгө оруулах үйл явц) хувьд гарах мөнгөн урсгал орох мөнгөн урсгалаас их байсан ба ялангуяа санхүүгийн салбарт гарах мөнгөн урсгал хамгийн их байлаа.

Эх сурвалж: Troweprice.com

Олон улсын индексүүд	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	16,523.81	0.18% ▲
Dow Jones	АНУ	26,428.32	-0.16% ▼
S&P 500	АНУ	3,271.12	1.73% ▲
Nasdaq	АНУ	10,745.27	3.69% ▲
S&P/TSX	Канад	16,169.20	1.08% ▲
FTSE 100	Их Британи	5,897.76	-3.69% ▼
S&P/ASX 200	Австрали	5,927.80	-1.60% ▼
Nikkei 225	Япон	21,710.00	-4.58% ▲
Hang Seng	Хонг Конг	24,595.35	-0.45% ▼

Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.750%	110.56
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.625%	102.10
Mongol 2022 (Чингис)	USD	5.125%	101.04
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.875%	104.59
DBM' 23 (Самурай)	JPY	1.520%	100.79
DBM' 2023	USD	7.250%	101.96
MGMTGE' 2022 (Өүлэн)	USD	9.750%	91.40

Зах зээлийн хүү	Хаалт	Өөрчлөлт
Libor 1M	0.155	-0.10 ▼
Libor 3M	0.249	0.01 ▲
Libor 6M	0.306	-0.04 ▼
Libor 1YR	0.449	-0.02 ▼
US 2YR Bond	0.111	-0.24 ▼
US 3YR Bond	0.125	-0.25 ▼
US 5YR Bond	0.223	-0.19 ▼
US 10YR Bond	0.554	-0.06 ▼

Валютын ханш	2020.07.31	Өөрчлөлт
USD	2,844.70	0.09% ▲
CNY	407.72	0.71% ▲
EUR	3,372.39	2.31% ▲
RUB	38.59	-2.77% ▼
KRW	2.39	1.27% ▲
JPY	27.18	1.57% ▲
CAD	2,120.22	0.21% ▲

Түүхий эд	Хэмжих нэгж	Хаалт	Өөрчлөлт
Алт /спот/	USD/t oz.	1,975.86	3.88% ▲
Мөнгө /спот/	USD/t oz.	24.39	7.13% ▲
Зэс	USD/lb.	286.80	-0.85% ▼
Нүүрс	USD/MT	53.07	-0.47% ▼
WTI газрын тос	USD/bbl.	40.27	-2.47% ▼
Brent газрын тос	USD/bbl.	43.30	-0.09% ▼
Байгалийн хий	USD/MMBtu	1.80	-0.55% ▼

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2020.VI	2.80%
Бодлогын хүү	2020.VI	9.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2020.VI	8.95%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2020.VI	10.98%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2020.VI	4.33%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2020.VI	17.03%
Зээлийн дундаж хүү /валют/	2020.VI	10.43%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg

## МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА


Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн биржийн хоёрдогч зах зээлийн энгийн арилжаагаар нийт 46 компанийн 1,264.9 сая төгрөгийн 2,079,115 ширхэг хувьцаа арилжаалагдав.

“Баянгол зочид буудал” /MSE: BNG/ компанийн хувьцаа 19.23%-аар буюу хамгийн ихээр өсөж 31,000.00 төгрөг хүрч хаагдсан бол “Жуулчин дюти фрий” /MSE: SUL/ компанийн хувьцаа 15.00%-аар буурч 67,150.00 төгрөгт хүрч хаагдлаа.

Компанийн бондын хоёрдогч зах зээл дээр “Лэндмн ББСБ” ХК-ийн 1.3 сая төгрөгийн 13 ширхэг үнэт цаас арилжаалагдав

Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч болон хоёрдогч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.

7-р сарын 31-ний өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,635.2 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 16,523.81 нэгж болж, өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 0.18% -аар өссөн байна.



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

### Зах зээлийн тойм

Зах зээлийн тойм	Дүн (сая.төг)
Арилжигдсан үнийн дүн	1,266.23
Зах зээлийн үнэлгээ	2,635,154.02

### Зах зээлийн индексүүд

Зах зээлийн индексүүд	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	16,523.81	0.18% ▲
MSE I индекс	8,049.18	1.44% ▲
MSE II индекс	7,395.87	-0.32% ▼

### Идэвхтэй арилжагдсан хувьцаа

Идэвхтэй арилжагдсан хувьцаа	Ширхэг	Үнийн дүн
Инвекор ББСБ	458,054	984,187,320
Эрдэнэ ресурс девелопмент корп	77,759	63,277,949
Бодь даатгал	421,780	45,545,134
АПУ	53,756	29,860,207
Ард даатгал	33,655	24,029,789

### Өсөлттэй хувьцаа

Өсөлттэй хувьцаа	Хаалт	Өөрчлөлт
Баянгол зочид буудал	31,000.00	19.23% ▲
Монгол даатгал	1,725.00	15.00% ▲
Ариг гал	2,990.00	14.96% ▲
Монгол нэхмэл	2,000.00	14.29% ▲
АПУ	579.99	5.73% ▲

### Бууралттай хувьцаа

Бууралттай хувьцаа	Хаалт	Өөрчлөлт
Жуулчин дюти фрий	67,150.00	-15.00% ▼
Бэрх уул	600.00	-14.29% ▼
Цагаантолгой	1,150.00	-8.00% ▼
Тандэм инвест ББСБ	17.90	-7.25% ▼
Ноёт хайрхан	340.00	-6.34% ▼

### Арилжаанд идэвхтэй оролцсон ҮЦК

Арилжаанд идэвхтэй оролцсон ҮЦК	Дүн (төг)
Инвекор Капитал	1,938,008,875.00
БиДиСек	200,522,120.71
Ард Секюритиз	138,210,060.29
Ти Ди Би Капитал	46,129,326.43
Стандарт Инвестмент	32,209,012.13

### Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани

Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани	Хаалт (төг)	33Ү (сая.төг)
АПУ	579.99	617,214.66
Таван толгой	5,520.00	290,711.90
МИК холдинг	12,990.00	269,014.07
Инвекор ББСБ	2,535.00	181,830.27
Говь	187.97	146,637.75

### Компанийн бондын хоёрдогч зах зээлийн арилжаа

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
1	LNBO-BD-19/06/21-C0008-17	5	500,000	100,000	100,000	52	17%
2	LNBO-BD-19/06/21-C0008-17	4	400,000	100,000	100,000	52	17%
3	LNBO-BD-19/06/21-C0008-17	4	400,000	100,000	100,000	52	17%

## НОГДОЛ АШИГ ЗАРЛАСАН ХУВЬЦААТ КОМПАНИУД

№	СИМБОЛ	КОМПАНИЙН НЭР	2019 ОНЫ ЦЭВЭР АШИГ /САЯ ТӨГ/	НИЙТ ХУВААРИЛАХ НОГДОЛ АШИГ /САЯ ТӨГ/	НОГДОЛ АШИГ ТӨЛӨЛТИЙН ХАРЬЦАА	НЭГЖ ХУВЬЦААНЫ НОГДОЛ АШИГ /ТӨГ/	БҮРТГЭЛИЙН ӨДӨР	ХУВААРИЛАХ ӨДӨР
1	APU	АПУ	74,411.5	75,471.2	101.4%	71.0	2020.02.14	2020.05.28-НД ОЛГОВ
2	MNDL	МАНДАЛ ДААТГАЛ	5,820.3	2,497.2	42.9%	4.0	2020.04.01	2020.06.29-НД ОЛГОВ
3	GTL	ГУТАЛ	2,403.7	2,436.0	101.3%	1,520.0	2020.03.13	2020.05.05-НЫ ӨДӨР
4	LEND	ЛЭНДМН ББСБ	4,910.2	1,200.0	24.4%	1.5	2020.02.25	2020.04.30-НД ОЛГОВ
5	ADB	АРД КРЕДИТ ББСБ	2,369.4	1,184.7	50.0%	4.2	2020.04.08	2020.04.29-НД ОЛГОВ
6	AARD	АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ	3,404.8	1,000.0	29.4%	35.0	2020.04.07	2020.06.30-НД ОЛГОВ
7	TUM	ТҮМЭН ШУВУУТ	3,232.9	960.0	29.7%	4.8	2020.04.07	2020.06.30-НД ОЛГОВ
8	AIC	АРД ДААТГАЛ	1,718.7	850.0	49.5%	34.0	2020.04.09	2020.06.30-НЫ ДОТОР
9	JTB	ЖЕНКО ТУР БЮРО	1,253.8	799.9	63.8%	10.0	2020.03.27	2020.06.30-НЫ ДОТОР
10	TEX	ТЕХНИК ИМПОРТ	2,718.2	723.4	26.6%	500.0	2020.03.01	2020.04.24-ӨӨС
11	BUK	УЛААНБААТАР БУК	2,465.3	526.2	21.3%	4.0	2020.03.30	2020.07.09-НД ОЛГОВ
12	MMX	МАХИМПЕКС	819.3	456.1	55.7%	120.0	2020.04.03	2020.10.01-ЭЭС
13	MFC	МОНОС ХҮНС	761.9	408.9	53.7%	1.0	2020.03.11	2020.08.31-НИЙ ДОТОР
14	DSS	ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦТС	581.8	391.8	67.3%	37.7	2020.03.20	2020.09.02-НЫ ӨДӨР
15	MNP	МОНГОЛ ШУУДАН	1,103.6	331.1	30.0%	3.3	2020.04.05	2020.07.30-НД ОЛГОВ
16	HRM	ГЕРМЕС ЦЕНТР	820.0	322.0	39.3%	4.1	2020.02.28	2020.04.16-НД ОЛГОВ
17	NEH	ДАРХАН НЭХИЙ	2,327.6	230.8	9.9%	210.0	2020.02.25	2020.09.30-ААС
18	TCK	ТАЛХ ЧИХЭР	2,456.0	230.3	9.4%	225.0	2020.02.18	2020.06.20-ООС
19	MBW	МОНГОЛ БАЗАЛТ	335.0	225.7	67.4%	4.0	2020.03.09	2020.07.03-НД ОЛГОВ
20	BNG	БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ	2,117.8	152.3	7.2%	360.0	2020.04.05	2020.09.01-НИЙ ӨДӨР
21	BDS	БИДИСЕК	19.9	136.9	687.0%	10.0	2020.03.09	2020.12.31-НЫ ДОТОР
22	EER	АРИГ ГАЛ	225.8	131.0	58.0%	38.9	2020.03.27	2020.07.08-НД ОЛГОВ
23	TAN	ТАХЬКО	489.0	128.5	26.3%	108.0	2020.04.10	2020.05.04-НД ОЛГОВ
24	UBH	УЛААНБААТАР ХИВС	298.8	121.4	40.6%	300.0	2020.03.06	2020.04.17-НД ОЛГОВ
25	HRD	ХҮРД	722.6	72.4	10.0%	535.0	2020.03.02	2020.06.30-НЫ ДОТОР
26	ATR	АТАР ӨРГӨӨ	280.4	60.9	21.7%	350.0	2020.04.01	2020.07.31-НД ОЛГОВ
27	MCH	МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО	62.0	25.9	41.7%	1.0	2020.04.06	2020.06.29-НД ОЛГОВ
28	HUV	ХӨВСГӨЛ ГЕОЛОГИ	324.7	21.6	6.7%	150.0	2020.04.03	2020.05.01-ЭЭС
29	SUU	СҮҮ	5,668.0	1,715.1	30.3%	5.0	2020.03.27	2020.05.01-ЭЭС
30	HZB	ГАН ХЭРЛЭН	31.9	15.0	46.9%	150	2020.04.06	2020.09.30-НЫ ДОТОР
31	BTG	БАЯНТЭЭГ	2,166.2	500.0	23.1%	1,979.3	2020.02.07	2020.12.01-НИЙ ДОТОР
32	TTL	ТАВАН ТОЛГОЙ	48,062.7	43,238.0	90.0%	821.0	2020.04.03	2020.07.21-НД ОЛГОВ
33	ERS	МОНГОЛ АЛТ	71.3	39.9	55.9%	150.0	2020.04.29	2020.12.31-НИЙ ДОТОР
34	TEE	ТЭЭВЭР ДАРХАН	10.9	0.8	749.1%	500.0	2020.04.29	2020.12.31-НИЙ ДОТОР

## ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

### ОНЦЛОХ МЭДЭЭ



СЗХ-ны Улсын байцаагчийн 2020 оны 7-р сарын 28-ны өдрийн 97 тоот албан шаардлагын дагуу “Монгол даатгал” /MSE: MDIC/ ХК-ийн үнэт цаасны арилжааг 2020 оны 7-р сарын 29-ний өдрөөс эхлэн нээлээ.

Тус компани нь үнэт цаас гаргагчийн “СНЭ” гэх үсгэн кодыг “MDIC” болгон өөрчлүүлэхээр хүсэлт гаргасантай холбогдуулан “Монгол даатгал” /MSE: MDIC/ ХК-ийн үнэт цаасны арилжааг СЗХ-ны Улсын байцаагчийн 2020 оны 7-р сарын 06-ны өдрийн 95 тоот албан шаардлагаар түр зогсоогоод байсан билээ.

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

### ХУВЬЦААТ КОМПАНИУДЫН МЭДЭЭЛЭЛ

**“Ард санхүүгийн нэгдэл” /MSE: AARD/ ХК 2020 оны эхний хагас жилийн санхүү, үйл ажиллагааны тайлангаа танилцууллаа.**

“Ард санхүүгийн нэгдэл” /MSE: AARD/ ХК нь 2020 оны эхний хагас жилийн санхүү, үйл ажиллагааны тайлангаа 2020 оны 7-р сарын 29-ний өдөр олон нийтэд танилцууллаа.

“Ард Санхүүгийн Нэгдэл” ХК нь өмнөх оны 2-р улирлын байдлаар 1.7 тэрбум төгрөгийн алдагдалтай ажиллаж байсан бол 2020 оны эхний хагасын байдлаар 777.1 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна. Тайлант хугацаанд дараах голлох үр дүнд хүрсэн байна. Үүнд:

- Нийт хөрөнгийн хэмжээ 73.3 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 200 сая төгрөгөөр буюу 1%-аар өсчээ.
- Хөрөнгө оруулалтын орлого өссөнөөр хагас жилийн байдлаар 777.9 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллажээ.
- Ард Апп-ыг хөгжүүлэн 3.0 хувилбарыг гаргаснаар илүү олон шинэлэг үйлчилгээг харилцагчдадаа санал болгож байгаа бөгөөд Хөрөнгө оруулагч үндэстэн Европт, Хувьцаатай хүүхэд- Ирээдүйн эзэд зэрэг аянж амжилттай өрнүүлж байна.
- Хамтын хөрөнгө оруулалтын сан байгуулах “Ард Менежмент” ХХК-ийн хүсэлтийг СЗХ-оос зөвшөөрсний дагуу энэ оны хоёрдугаар хагаст “Үндэсний Хувьчлалын Сан”-г үүсгэн байгуулж, олон нийтээс хөрөнгө төвлөрүүлэхээр ажиллаж байна. Энэхүү сан үүсгэн байгуулагдсанаар Монголд олон нийтээс хөрөнгө татан төвлөрүүлэх анхны хөрөнгө оруулалтын сан болох юм.

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

**“Ард даатгал” /MSE: AIC/ ХК 2020 оны эхний хагас жилийн санхүү, үйл ажиллагааны тайлангаа танилцууллаа.**

“Ард даатгал” /MSE: AIC/ ХК нь 2020 оны эхний хагас жилийн санхүү, үйл ажиллагааны тайлангаа 2020 оны 7 дугаар сарын 29-ний өдөр олон нийтэд танилцууллаа. Тайлант хугацаанд:

- Нийт хөрөнгө өмнөх оныхоос 1.7 тэрбум төгрөгөөр буюу 7.8%-аар өсч, 23.6 тэрбум төгрөгт хүрсэн байна.
- 7.7 тэрбум төгрөгийн хураамжийн орлого төвлөрүүлсэн ба цэвэр хураамжийн орлого өмнөх оны мөн үеэс даруй 32.7%-аар өссөн үзүүлэлттэй байна.
- 2020 оны эхний хагас жилд 585 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан нь өнгөрсөн оны мөн үеэс 57%-аар буурсан үзүүлэлт болжээ.
- 2019 оны цэвэр ашгаас хувьцаа эзэмшигчиддээ 850 сая төгрөгийн ногдол ашгийг амжилттай хуваарилсан байна.

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

**“Ард кредит ББСБ” /MSE: ADB/ ХК 2020 оны эхний хагас жилийн санхүү, үйл ажиллагааны тайлангаа танилцууллаа.**

“Ард кредит ББСБ” /MSE: ADB/ ХК нь 2020 оны эхний хагас жилийн санхүү, үйл ажиллагааны тайлангаа 2020 оны 7 дугаар сарын 29-ний өдөр олон нийтэд танилцууллаа.

Тайлант хугацаанд “Ард Кредит ББСБ” /MSE: ADB/ ХК нь 4 тэрбум төгрөгийн үйл ажиллагааны орлого олж 548.8 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан бөгөөд дараах онцлох үр дүнгүүдийг гаргажээ. Үүнд:

- Нийт хөрөнгө 24.5 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оныхоос 5.9 тэрбум төгрөгөөр буюу 31.8%-аар өссөн;
- Цэвэр зээлийн багц өмнөх оноос 6.8 тэрбум төгрөгөөр буюу 52%-аар өсч 19.8 тэрбум төгрөгт хүрсэн;
- Цахим мөнгөний зөвшөөрлийг Монгол банкнаас авснаас гадна орон нутгийн иргэдэд цахим зээлийг олгож эхлээд байна;
- Япон улсын Крауд Кредит сангаас авсан санхүүжилтийг амжилттай эргэн төлсөн байна.

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

## ЗАХ ЗЭЭЛИЙН БУСАД МЭДЭЭ

### ОНЦЛОХ МЭДЭЭ

БНХАУ Монгол Улсад хилийн боомтын гаалийн хяналт шалгалтын тоног төхөөрөмж авахад зориулж 600 сая юанийн буцалтгүй тусламж олгож байна.

“Монгол Улсын хилийн боомтын гаалийн хяналт шалгалтын тоног төхөөрөмж нийлүүлэх” төслийг хэрэгжүүлэхэд олгож буй дээрх тусламжийн Солилцох захидалд Монгол Улсыг төлөөлж Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, БНХАУ-ын Засгийн газрыг төлөөлж тус улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн Эрхт Элчин сайд Цай Вэньруй нар өнөөдөр Сангийн яаманд гарын үсэг зурлаа. Дээрх төсөл нь манай улсын хилийн боомтуудын хяналт шалгалтад шаардлагатай тоног төхөөрөмж авахад зарцуулах, цаг үеэ олсон тусламж болохыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар онцлов

Эх сурвалж: Montsame.mn

### МАКРО ЭДИЙН ЗАСАГ

Монгол Улс энэ оны нэгдүгээр сараас “COVID-19” цар тахлаас иргэдээ хамгаалах зорилгоор өндөржүүлсэн бэлэн байдалд шилжиж хилээ хаасан.

Улмаар эдийн засаг зогсонги байдалд орж экспорт эрс буурснаар төсвийн орлого оны эхний хагас жилийн байдлаар 1.2 их наяд төгрөгөөр тасраад байна. Засгийн газраас иргэдийнхээ эрүүл мэнд, орлогыг хамгаалах, ААН-үүдээ дэмжих, эдийн засгийг сэргээх, эрчимжүүлэх чиглэлээр тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлэхийн зэрэгцээ шаардлагатай нэмэлт санхүүжилт дайчилж байна. Тухайлбал,

- хүүхдийн мөнгөн тэтгэмжийг 100 мянган төгрөг болгож нэмсэн,
- орлого багатай ядуу өрхүүдэд олгодог хүнсний бүтээгдэхүүн худалдан авах санхүүжилтыг хоёр дахин нэмсэн,
- орлого нь буурсан 6.9 мянган ААН-ийн 73 мянган хүнд сар бүр 200 мянган төгрөг олгосон,

Нийгмийн халамжийн тэтгэвэр авдаг иргэд болон байнгын асаргаа шаардлагатай хүүхдэд олгодог тэтгэмжийг 100 мянган төгрөгөөр нэмсэн зэрэгт одоогийн байдлаар 768 тэрбум төгрөг нэмж зарцуулжээ. Түүнчлэн иргэд, ААН, байгууллагуудын орлогыг хамгаалах зорилгоор нийт 1 их наяд 877.9 тэрбум төгрөгийн НДШ, Хувь хүний орлогын болон ААН-ийн орлогын албан татвар, түүний алданги, торгуулийг бүрэн чөлөөлсөн. “COVID-19” цар тахал нийтдээ 2.5 их наяд төгрөгийн төсвийн дарамт бий болгоод байна.

Төсвийн орлого их хэмжээгээр тасарч, төлөвлөөгүй зардал нэмэгдэн, нэмэлт эх үүсвэр зайлшгүй шаардагдаж байгаа ийм нөхцөлд Засгийн газар хөгжлийн түнш улс, олон улсын байгууллагуудтай идэвхитэй хэлцэл хийж нийт 301 сая ам доллар буюу 800 гаруй тэрбум төгрөгийн нэн хөнгөлттэй эх үүсвэрийг төсвийн дэмжлэг хэлбэрээр хүлээн авсан.

Гадаадын зээл, тусламж болон төсвийн эх үүсвэрээр иргэд, олон нийтэд чиглэсэн цалин тэтгэвэр, халамж, хүүхдийн мөнгөн тэтгэмж, эрүүл мэндийн салбар зэрэг төрийн үйлчилгээний зардлуудыг төсвийн хуулийн дагуу цаг хугацаанд нь бүрэн санхүүжүүлж байна.

Эх сурвалж: Montsame.mn

### ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛ

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон БНЭУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд М.П.Синхийг хүлээн авч уулзлаа.

Уулзалтын үеэр Монгол Улсад барьж буй газрын тос боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын явцын талаар ярилцаж, уг төслийг хэрэгжүүлэхтэй холбоотой ямар асуудал тулгамдаж байгаа болон газрын тосны салбарт цаашид хамтран ажиллах боломжийн талаар харилцан санал солилцлоо.

Манай улс Бүгд Найрамдах Энэтхэг Улсын 1 тэрбум ам.долларын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр жилд 1.5 сая тн дотоодын түүхий тос боловсруулах хүчин чадал бүхий “Газрын тос боловсруулах үйлдвэр барих” төслийг Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт хэрэгжүүлж эхлээд байгаа юм. Уг үйлдвэр ашиглалтад орсноор импортоос 100 хувь хараат байдаг манай улс газрын тосны бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээг бүрэн хангаж, нефьт-химийн үйлдвэрлэлийн салбарыг хөгжүүлэх эх суурь тавигдах юм.


Эх сурвалж: Montsame.mn

# ШИНЖЭЭЧИЙН БУЛАН


## МОНГОЛ УЛСЫН ЗЭСИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮДЭЭС



Эх сурвалж: ҮСХ, Аж үйлдвэрлэлийн статистик



Эх сурвалж: ҮСХ, Аж үйлдвэрлэлийн статистик



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

ҮСХ-ны аж үйлдвэрийн статистикаас харахад зэсийн үйлдвэрлэл буюу олборлолт 2009 онд 533.1 мянган тонн байсан бол 2019 оны байдлаар 1.2 сая тонн болж жилд дунджаар 9.0%-аар өссөн байна. 2012 он хүртэл зэсийн баяжмалын үйлдвэрлэл тогтмол байсан бөгөөд 2012-2016 оны хоорондох өсөлт нь Оюу Толгой төсөлтэй холбоотой байна. Зэсийн баяжмалын 35%-ийн агуулгад шилжүүлснээр тооцсон үйлдвэрлэл нь 2009 онд 370.9 мянган тонн байсан бол 2019 онд 378.2 тонн болсон байна. 2012 оноос тухайн үзүүлэлт огцом өсч 2015 онд 890.7 мянган тоннд хүрсэн бөгөөд 2016 оноос буцаж өмнөх түвшинд очсон байна.

Катодын зэсийн үйлдвэрлэл 2009 онд 2.5 мянган тонн байсан бол 2019 оны байдлаар 11.8 мянган тонн болтлоо өссөн байна.

### МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК нь мэдээллийн үнэн бодит байдал баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК хариуцлага хүлээхгүй болно.